**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

# ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ-СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН ЧИГЛЭЛИЙН 92 КМ АВТО ЗАМЫН ТАЛБАЙ

Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан

Тайлан бичсэн: А.Энхтөр – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор

Т.Батбаяр – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор

Э.Амарболд – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, магистр

Захиалагч байгууллага: “ЭМ СИ ПИ СИ” ХХК

Тайлан өмчлөгч: Археологийн хүрээлэн. Улаанбаатар-13343,
Жуковын гудамж-77
ШУА-ийн Нэгдсэн I байр
Утас: 11-452894, факс: 976-11-452899

**УЛААНБААТАР**
**2021**

Б хавсралт

Бүртгэлийн дугаар . . . . . . . .                Нууцын зэрэглэл: . . .

Гэрээний дугаар: . . .

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

# ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ-СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОН ЧИГЛЭЛИЙН 92 КМ АВТО ЗАМЫН ТАЛБАЙ

**Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан**


Тайлан бичсэн: А.Энхтөр – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор

Т.Батбаяр – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор

Э.Амарболд – Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, магистр


Захиалагч байгууллага: “ЭМ СИ ПИ СИ” ХХК


Тайлан өмчлөгч: Археологийн хүрээлэн. Улаанбаатар-13343, Жуковын гудамж-77
ШУА-ийн Нэгдсэн I байр
Утас: 11-452894, факс: 976-11-452899


9019090235 ... 6471072

**УЛААНБААТАР**
**2021**

**ГАРЧИГ**


Судалгааны багийн удирдамж ........................................................................................ 4

**1. Удиртгал** ................................................................................................................ 5

1.1. Судалгааны ажлын зорилго ...................................................................................... 5

1.2. Хуулийн хязгаарлалт ................................................................................................. 5

1.3. Арга зүй, аргачлал ..................................................................................................... 6

**2. Автозам тавигдах бүс нутагт хийсэн археологийн судалгаа** .................................. 10

2.1. Сэлэнгэ аймгийн нутагт хийсэн археологийн судалгааны байдал ........................... 10

2.2. Төв аймагт хийсэн археологийн судалгааны байдал ..................................................11

**3. Археологийн хайгуул судалгаа** ............................................................................... 17

3.1. Археологийн дурсгалуудын тодорхойлолт ................................................................ 17

3.2. Замын трассын ойр орчмоос илэрсэн дурсгалуудын байршил ................................ 38

**Хавсралт №1.** Замын трассын дагууд буй дурсгалуудын тархцыг харуулсан зураг .... 39

**Хавсралт №2.** Дурсгалуудыг авран хамгаалах зардлын төсөв ...................................... 40

**4. Судалгааны ажлын товч үр дүн** .............................................................................. 41

# АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

**Судалгааны ажлын үндэслэл, зорилго:**

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Дархан-Эрдэнэтийн чиглэлийн улсын чанартай А1001 авто замын Орхон сумын уулзвартай холбох замын гол шугамын дагууд археологийн хайгуул судалгаа хийж, археологийн дурсгал илэрсэн тохиолдолд тэдгээрийг бүртгэн баримтжуулна.

**Судалгаа хийх газар:**

Дархан-Уул аймаг, Орхон аймгийн нутаг дэвсгэрт, автозамын дагуу 850 км

**Судалгааны арга:**

Археологийн хээрийн шинжилгээний хайгуулын судалгааны арга зүйг ашиглана.

**Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн:**

1. А.Энхтөр *(ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны секторын эрхлэгч, доктор)*
2. Т.Батбаяр *(ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны секторын ЭША, доктор)*
3. Э.Амарболд *(ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ЭША)*
4. Жолооч-1.

***Санхүүжилт:***

- Эм Си Пи Си Жи Ар ХХК

***Багаж тоног төхөөрөмж:***

- Гэр, майхан, гал тогооны хэрэгсэл,
- Хайгуулын багаж хэрэгсэл

***Хугацаа:*** 2021 оны 10-р сар

***Унаа хөсөг:***

Тоёота ланд крузер-1.

**Маршрут:**

УБ-Дархан-Эрдэнэт-УБ

***Судалгааны урьдчилсан үр дүн:***

Археологийн малтлага судалгааны ажлын материалыг боловсруулан эрдэм шинжилгээний тайлан бичих, гэрээнд заасан хугацаанд захиалагч талд хүлээлгэн өгөх болно.

Удирдамж боловсруулсан: А.Энхтөр

# УДИРТГАЛ

## 1.1. Судалгааны ажлын зорилго

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан шаардлагын дагуу урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэхээр “Эм Си Пи Си Жи Ар” компани хүсэлт гаргаж, уг хүсэлтийн дагуу ШУА-ийн Археологийн хүрээлэн Соёлын өвийг хамгаалах хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 27.6, 27.8, 27.9 заалтын үндэслэн ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны салбарын эрхлэгч, доктор (Ph.D) А.Энхтөр, доктор (Ph.D) Т.Батбаяр, Э.Амарболд нар бүтээн байгуулалтын хамрах талбайд өртөх хэсэгт трассын дагуу археологийн нарийвчилсан хайгуул судалгааны ажлыг 2021 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэв.

## 1.2. Хуулийн хязгаарлалт

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 7 дугаар зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-д 27.8.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна. 27.9.Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна. 27.10.Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно хэмээн заасан байна.

Мөн БСШУ-ны Сайдын 2010 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 222 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Монгол улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дахь заалтанд “Хот суурин, барилга байгууламж, усан цахилгаан станц, уул уурхайн үйлдвэр барьж байгуулах, зам тавих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь уг ажлыг эхлэхийн өмнө Мэргэжлийн зөвлөлд хандах бөгөөд зөвлөл нь мэргэжлийн шинжээчдийг томилон тухайн газар нутагт түүх, археологийн дурсгалт зүйл байгаа эсэх талаар тандалтын урьдчилсан малтлага судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна”; “Тандалтын малтлага, судалгаа хийх, олдворыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг энэ журмын 2.4-т заасан үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж хариуцна” хэмээн тус тус заасан байна. Монгол улс нэгдэн орсон соёлын өвтэй холбоотой ЮНЕСКО-ийн конвенциуд. Олон улсын хамтын нийгэмлэг – ЮНЕСКО 1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай Конвенци, 2003 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийг тус тус батлан гаргасан нь дэлхий нийтэд түгээмэл ач холбогдолтой, хосгүй гайхамшигт байгалийн болон соёлын өвүүд, улс үндэстэн бүрийн амьдралын хэв шинж, өвөрмөц онцлогийг тугасан, түүний нэрийн хуудас, таних тэмдэг болсон соёлын биет бус өвүүдийг хадгалж хамгаалах, өвлүүлэх үйл явцад томоохон алхам болсон юм.

Монгол Улс 1964 онд, “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенци”-д нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирлээ.

Монгол Улс 1990 оноос хойш хүн төрөлхтний нийтлэг замд нэгдэж, дэлхий дахинд нээлттэй болж эхэлсэн нь олон улсын чанартай гэрээ, конвенцид нэгдэн орж ажиллах нөхцлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1990 онд ЮНЕСКО-гийн “Дэлхийн

соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци”-д, 1991 онд “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенци”-д, 2005 онд “Биет бус соёлын өвийн конвенци”-д, 2007 онд “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенци”-д тус тус нэгдэж орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд болон шаардлагыг соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган хэрэгжүүлж эхэлсэн байна.

### 1.3. Арга зүй, аргачлал

**Археологийн хайгуулын арга зүй, аргачлал**

Ямарваа нэгэн зүйлийг зохион байгуулалттайгаар эрэн хайж, олж тогтоох үйлдлийг хайгуул гэдэг билээ. “Хайгуул” гэдэг нь ихэвчлэн шинжлэх ухааны үг хэллэгэнд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь геологи, палеонталоги, биологи, археологи зэрэг шинжлэх ухааны салбарт түгээмэл ойлголт билээ. Хайгуул нь археологийн судалгааны хамгийн эхний шатны бөгөөд хариуцлагатай ажил юм.

**Ангилал**

Археологийн хайгуул судалгаа нь эртний түүх соёлын дурсгалыг эрэн хайж, илрүүлэн олох, тодорхойлон, судлан, шинжлэх зорилготой өөрийн гэсэн арга зүйд тулгуурласан судалгааны ажлын нэгэн хэлбэр юм. Археологийн хайгуул судалгааны ажлыг дотор нь нэгдүгээрт, нарийвчлалтай хайгуул, хоёрдугаарт, энгийн, гуравдугаарт хялбаршуулсан гэж гурав хуваан авч үзэж болно.

Нарийвчлалтай хайгуул гэдэг нь хөндий, тэгш тал газар хайгуул судалгаа хийх арга зүй юм. Энэхүү арга зүйг уртраг, өргөргийн дагуу шугаман хайгуулыг гүйцэтгэхэд ашиглах бөгөөд овор хэмжээтэй дурсгалыг хайж олохоос гадна газрын хөрсөн дээр буй хүний нүдэнд тэр бүр ажиглагдахгүй чулуун зэвсэг, шавар савны хагархай, зарим жижиг эд өлгийн зүйлсийг илрүүлэн олоход чиглэгдэнэ.

Ямарваа нэгэн зүйл олсон тохиолдолд түүний байршлын солбилцолыг тогтоох, тухайн олсон зүйлийн талаар тодорхойлолт бичих, олдворыг баримтжуулах зэрэг ажлыг гүйцэтгэж дараагийн шатанд өргөтгөсөн малтлага хийх эсэх талаар зөвлөлдөнө.

Энэхүү хайгуулын арга зүйг уул уурхайн компанийн ашиглалтын талбай болон хайгуулын талбайд хэрэглэх хэрэгтэй юм. Учир нь ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын талбай нь хэмжээний хувьд том, жижиг янз бүр байх боловч тодорхой хүрээнд хязгаарлагдсан байдгаас гадна цаашид энэ газар нь эвдэгдэх, бүрэн устах магадлалтай учир илүү нарийвчлалтай хийх нь зүйтэй.

Энгийн хайгуул. Энэхүү хайгуулын арга зүйг тачир өвстэй уулын бэл, голын дагуух довцог, хуурай сайранд хайгуул хийхэд ашиглахад тохиромжтой. Хайгуулын энэхүү арга зүй нь ямар нэгэн бүс нутагт хайгуул болон дурсгалын талаар тодорхой хэмжээний туршлага мэдээлэл хуримтлуулсны үндсэн дээр хайгуулыг илүү хурдан, олон хүнийг хамарсан байдалтай хийхэд чиглэгдэнэ. Мөн газрын зургийн хүрэлцээ муу буюу тухайн бүсийн нарийвчлалтай газрын зураг байхгүй тохиолдолд агаарын зургийг ашиглан хайгуулыг хийхэд хэрэглэнэ. Учир нь агаарын зураг тодорхой өндрөөс авсан гэх боловч зарим тохиолдолд зургийн алдаа, чанар зэргээс хамаарч газар орчин сайн харагдахгүй, шугамын талаар нарийн мэдээлэл байхгүй зэрэг дутагдалтай байдаг.

Хайгуулын ажлын хамгийн эхэнд агаарын зургийн тусламжтайгаар сонгосон талбайн дөрвөн захын цэгийг GPS багажаар тодорхойлно. Дараа нь хүн тус бүрийн хоорондын зайг хэлэлцэн тогтоно. Талбайн аль нэгэн захаас тогтсон зайгаар явж нөгөө зах хүрэх зэргээр нааш цааш уртраг, өргөргийн дагуу хайгуулыг хийж гүйцэтгэнэ. Ингэснээр нэг шугаманд эгнэн хайгуул гүйцэтгэж байсан хайгуулын хэсэг нь хэд хэдэн хэсэг болон задарч хайгуулын талбайд өөрсдийн сонголтоор хийж гүйцэтгэх боломжтой болно.

Хайгуулын хэсэг болгон өөрсдийн хайгуулын мэдээллийн дэвтэр, дурсгалын ерөнхий дэвсгэр зураг үйлдэх дэвтэр, фото аппарат, GPS зэрэг багаж хэрэгслийг хэрэглэнэ.

Хялбаршуулсан хайгуул. Энэ хайгуулын арга зүйг сонгож авсан хайгуул хийх талбай болон түүнээс гадагш харьцангуй хол талбайд хайгуул хийхэд хэрэглэнэ. Гол болон уулсын хоорондох битүү мод бүхий хайгуулын талбайд тухайн хайгуулын хэсэг ямар нэгэн зайд баригдахгүй, хүн явах боломжтой газраар явж шалгаж үзнэ. Ийм уулын бүсэд археологийн дурсгал ховор байдаг боловч хайгуулын гол зорилго бол сонгосон талбайдаа ямар нэгэн газрыг үлдээлгүй, олон янзын арга зүйгээр хайгуулд хамруулах явдал билээ. Мөн өөр нэгэн зүйл бол сонгосон хайгуулын талбайгаас гадагш ойролцоо зарим газрыг үзэж танилцах, өөрсдийн талбайтай харьцуулах зайлшгүй шаардлага урган гарна. Талбай илүү том, зам урт учир үүнийг автомашинаар хийж гүйцэтгэж болдог. Автомашин явах боломжтой ам, хөндийгөөр орж дурсгалтай танилцах, тэдгээрийн баримтжуулалтыг хийнэ.

Хайгуулд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл. Археологийн хайгуулыг хийж гүйцэтгэхэд олон тооны багаж, комьпютерийн хэрэгсэлийг өргөн ашигладаг билээ. Үүнд, газрын байршилыг тодорхойлох GPS багаж, GPS багажаар хэмжсэн хэмжилтийг компьютерт оруулан газрын зурагт тэмдэглэх GIS буюу Archview программууд багтана.

**Дурсгалын баримтжуулалт**

Дурсгалын баримтжуулалт нь мэдээллийн сан бүрдүүлэх, цаашдын судалгааг тодорхойлох, дүн шинжилгээ өгөх, хадгалах, хамгаалах талаарх зөвлөмж гаргахад хамгийн чухал шаардлагатай ажил юм.

Хайгуулын явцад ямар нэгэн дурсгал илрүүлэн олсон тохиолдолд доорхи баримтжуулалтыг гүйцэтгэсэн болно. Үүнд,

1. Шугаман хайгуул гүйцэтгэж буй хайгуулын багийн гишүүн дурсгал олсон тохиолдолд бусад оролцогчдыг дуудан хамтран тухайн дурсгалыг бүртгэх ажлыг гүйцэтгэнэ.
2. Дурсгалын дугаарлалт
   - Дурсгалыг дугаарлахдаа хайгуул гүйцэтгэж байгаа талбай болон газрын нэрийг бүтнээр нь буюу товчилсон үгээр илэрхийлээд (Жишээлбэл, Шанага-001, Дэрст-001, Совог-001 гэх мэт) ард нь нэгээс эхлэн дугаарлана. Гэхдээ энэ нэр нь цаашид мэдээллийн санд өгөгдөл болон орох тул өмнөх хайгуулын нэр болон цаашид хийх хайгуулын нэрийг бодолцох нь зүйтэй.
3. Тодорхойлолт бичих
   - Тодорхойлолтыг тусгайлан бэлдсэн дэвтэрт дэс дугаарын дагуу бичнэ. Дэвтрийн эхний нүүрэнд тухайн тодорхойлолт бичих хүнд зориулан чухам ямар мэдээлэл оруулахыг сануулсан товч асуултууд бэлдэнэ.
   - Газрын ерөнхий байдлыг тодорхойлно.
   - Дурсгалтай ойрхон байгаа уул, гол, нуур зэрэг газруудын нэрийг тодорохойлно.
   - Дурсгалын гадаад байдлыг тодорхойлох
   - Дурсгалын эвдрэл гэмтэл
   - Дурсгалын хэмжээг авна. Үүнд анхаарах нэг зүйл байдаг. Энэ бол ямар ч дурсгалыг хойноос урагш, зүүнээс баруун тийш буюу уртраг, өргөрөгийн дагуу хэмжинэ. Нэгдсэн нэг аргачлалтай хэмжилт нь хайгуулын мэдээнд тулгуурласан харьцуулсан судалгаа хийхэд тус болдог.
   - Солбицолыг тодорхойлох. Энэ нь мэдээллийн сангийн нэгэн чухал хэсэг бөгөөд солбицолыг UTM эсвэл Lat/Lon hddd.ddddd° форматаар сануулж WGS84 гэсэн солбицолын тохиргоог анхаарах нь зүйтэй.
4. Гэрэл зураг авах. Энэ ажил нь дурсгалын талаарх мэдээллийг бүхэлд хамруулан гэрэл зурагт буулгаад цаашид мэдээллийн сангийн чухал нэгэн эх сурвалж болно.

- Дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, он сар өдрийг бичсэн самбарыг бэлдэнэ.
- Самбарыг дурсгалын гадаад зохион байгуулалтыг халхлахгүйгээр тохиромжтой газар тавиад гэрэл зураг авна. Самбар дээр бичсэн зүйлс нь дурсгалыг мэдээллийн санд оруулахад чухал зүйл учир харагдахуйц бичих хэрэгтэй.
- Самбарын урд талд хойд зүгийг заасан тэмдэглэгээ тавих. Энэ нь хожим тухайн дурсгалын гадаад зохион байгуулалт, хэлбэрийн ангилал, газар нутгийн тодорхойлолт хийхэд тус болдог.
- Хэмжээс тавих. Хэмжээсийг харагдахуйц газар уртраг, өргөргийн дагуу хандуулан тавина. Том дурсгалд 100-200 см, жижиг дурсгалд 20-50 см хэмжээтэй хэмжээсийг тавибал илүү тохиромжтой. Энэ нь тухайн дурсгалын талаар хожим хэмжээний талаар мэдээлэл авахад хэрэг болох болно.
- Гэрэл зураг авахдаа дурсгалыг гол цэгээ болгох нь дамжиггүй боловч цаад талд харагдаж байгаа уул, гол, жалга зэрэг зүйлсийг ямар нэгэн хэмжээгээр оруулан авах хэрэгтэй.

5. Олдвор түүвэрлэх. Энэ нь чулуун зэвсэг, ваарны хагархай, төмөр зэсийн баас гэх мэт жижиг хэмжээтэй олдворыг түүвэрлэх ажил юм.
   - Тухайн газарт хамгийн эхэнд хийх ажил бол олдворын тархалтыг тодорхойлох юм. Үүнийг гүйцэтгэхдээ олдворын дэргэд тод өнгийн зориулалтын туг, дарцагийг хатгана. Ингэснээр тархалтыг нүдээр харах боломжтой болох юм.
   - Уртраг, өргөргийн дагуу тархалтыг хэмжин тодорхойлолтонд тусгана.
   - Тархалтыг тодорхойлсны дараа хамгийн нягтрал ихтэй газрыг сонгон 1 м.кв талбайд хичнээн олдвор ноогдож байгааг тэмдэглэнэ.
   - Олдвор бүхий дурсгалт газраас дээж болгон заримыг түүвэрлэн авч болох боломжтой боловч цаашид сорилтын малтлага болон дараа дараагийн судалгаанд зориулан тухайн газарт нь олдворуудыг үлдээх нь зүйтэй.

Хэрэв олдвор түүвэрлэх зайлшгүй шаардлагатай бол зориулалтын уутанд хамт дурсгалын дугаар, хайгуулын талбайн дугаар, солбицол зэрэг мэдээллийг бичиж хийнэ.

6. Дэвсгэр зураг үйлдэх. Энэ баримтжуулалтын ажил нь гэрэл зураг дээр гарах боломжгүй илүү мэдээллээр хангах зорилготой хийдэг.
   - Дэвсгэр зургийг тойм байдлаар зурна. Учир нь тухайн дурсгал нь хөрсөнд булагдаж анхны төрхийг тодруулах боломжгүй, хайгуул нь цааш үргэлжлэх хугацааг хэмнэхээр тооцоолж буй хэрэг юм.
   - Хайгуулын багийнханд тодорхойлолт бичих дэвтэр, дэвсгэр зураг зурах гэсэн хоёр дэвтэр байна.
   - Дэвсгэр зургийг үйлдэхдээ масштабыг дэвтэртээ тааруулахаас гадна, хожим ойлгомтой байх зорилтыг анхаарах хэрэгтэй.
   - Дурсгалын хойд урд тэнхлэгийн дагуу метр тавьж зурна. Том хэмжээтэй дурсгал дээр тойм төдий зургийг зурж болно.
   - Тэнхлэгийн дагуу масштабаар жижгүүлэн дурсгалын ерөнхий хэлбэрийг зөв гаргана.
   - Мөн зарим тохиолдолд олон дурсгалтай газарт уул, жалга, гол зэрэг онцгой газруудыг тэмдэглэн нүдэн баримжаагаар дурсгалуудын байршлыг зурж болно.
7. Хөрсний шалгалт. Энэ арга зүйг өндөр өвсөөр хучигдсан газарт ашиглана. Тухайн газарт олдвор хүний нүдэнд тодорхой сайн харагдахгүй, хөрсөн доор байх магадлалтай хэмээн үзэж хайгуулд оролцогчид тодорхой зайд, тодорхой хэмжээний газрыг сонгон хүрзээр малтах ажил юм.

- Хайгуул оролцогчид уртраг, өргөргийн дагуу самнах шугаман хайгуулыг хийхдээ хүрз болон шигшүүртэй гүйцэтгэнэ.
- Хайгуулд дунджаар 6 хүн оролцож байгаа тохиолдолд 3 хүн хүрз, 3 хүн шигшүүртэй солбин явах бөгөөд шигшүүртэй оролцогч зүүн талд, хүрзтэй оролцогч баруун талд нь гэх мэтээр зохион байгуулж болно.
- Шугаман хайгуулын 100 м тутамд (үүнийг хайгуулыг ахлаж байгаа оролцогч GPS багажны зай хэмжүүрийн тусламжтайгаар тодорхойлж, бусад оролцогчдод хөрсний шалгалт хийхийг сануулна) нийт хайгуулд оролцогчид зэрэг буюу хүрз авч яваа хүн дунджаар 50х50 см хэмжээтэй, 20-30 см гүнтэй нүхийг малтана. Үүнд зүүн талд яваа шигшүүртэй оролцогч ирж хөрсийг бүрэн шигшиж, ямар нэгэн олдвор байгаа эсэхийг шалгана. Хэрэв шигшүүрээс 5 болон түүнээс дээш олдвор гарсан тохиолдолд дурсгал хэмээн үзэж баримтжуулалт хийнэ. Харин 5-аас доош олдвор гарсан тохиолдолд хайгуулын мэдээнд оруулаад хайгуул цааш үргэлжилнэ.

## 2. АВТОЗАМ ТАВИГДАХ БҮС НУТАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

### 2.1. Сэлэнгэ аймгийн нутагт хийсэн археологийн судалгааны байдал

МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги 1976 онд Сэлэнгэ аймгийн нутгаар явж Зүүнхараа сумын нутаг Бороо голын зүүн хөвөөнд байсан хятад бичээстэй хөшөөг авч ирэн судалж эрдэм шинжилгээний тайлан бичжээ.

1979 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Д.Дорж, Д.Цэвээндорж, Зөвлөлтийн талаас Академич П.Окладников,эрдэм шинжилгээний ажилтан А.Конопацкий, И.Асеев, Ю.С.Худяков нарын бүрэлдэхүүнтэй МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Сэлэнгэ аймгийн нутагт хайгуулын ажил хийж гүйцэтгэн цуглуулсан шинэ чулуун зэвсгийн үеийн зэвсэг багажийн зүйлд ангилал хийж боловсруулан Түүхийн хүрээлэнгийн лабораторид тушаасан байна. 1980 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги чулуун зэвсгийн судалгаа хийж байсан бол 1980 онд Хархорумын шинжилгээний анги Баруунбүрэн сумын нутагт хадны зургийн судалгаа хийн холбогдох тайланг бичиж Түүхийн хүрээлэнд хүлээлгэн өгсөн байна.

1990 онд Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Д.Баяр, Х.Лхагвасүрэн нарын судлаачид Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул сумдын нутагт буй түрэгийн үеийн цогцолбор дурсгал, хүн чулуун хөшөө, буган хөшөө, булш, хиргисүүр зэргийг үзэн тодорхойлолт хийж, судалгааны ажлын талаар эрдэм шинжилгээний тайлан бичсэн байна.

Мөн онд Хүннүгийн дурсгал судлах Монгол-Унгарын хамтарсан хээрийн шинжилгээний анги Сэлэнгэ аймгийн Октябрийн САА-н Загдалын гол орчим хайгуул судалгааны ажил хийн холбогдох тайланг бичиж нийтлүүлжээ.

1994 онд Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги Орхон сумын нутагт хайгуул судалгаа хийж байжээ.

1996 онд Монгол-Америкийн хамтарсан хээрийн шинжилгээний анги Орхонтуул сумын нутаг Бичигтэй эрүү, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Эгийн голын сав Баянгол, Бурхан толгой, Дархан уул, Хайлаантын гол зэрэг газарт он цагийн хувьд хүрэл, хүннү болон монголын хожуу үед холбогдох нийт 13 орчим булш малтан судалжээ. Дээрх аймгуудын нутагт явуулсан археологийн хээрийн судалгааны материалыг боловсруулж тайлан бичсэн байна.

1996 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Д.Эрдэнэбаатар, Б.Цогтбаатар нарын судлаачид Түшиг сумын нутаг Тавтын талд археологийн хайгуулын хайгуул судалгааны ажил хийн сумын төвөөс баруун хойш Зэлтэр голын хойд эргийн дагуу орших Тавтын талд нүүрсний ил уурхай нээж байгаатай холбогдон Монгол улсын <<Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай>> хуулийн 6-р бүлгийн 1-д <<Аливаа үйлдвэр, уурхай, хот суурин, барилга байгууламж барихад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул хийлгэж зөвшөөрөл авна>> гэж заасны дагуу тус уурхайн ашиглалтын талбайд археологийн урьдчилсан хайгуул хийж, нийтдээ 25 орчим (Монголын эзэнт улсын үеийн булш 10, хүрэл төмрийн үеийн булш 5, түрэгийн үеийн булш 10) эртний булш, хиргисүүр зэрэг монголын түүх соёлын дурсгалт зүйлүүд илэрснийг тодорхойлоод уг талбай дахь археологийн дурсгалыг чөлөөлөх тухай холбогдох тооцоо, судалгааг захиалагч байгууллага Уул уурхайн хүрээлэнд хүлээлгэн өгсөн байна.

1997 онд Монгол-Солонгосын хамтарсан “МонСол” төслийн судлаачид Сэлэнгэ аймгийн нутагаар явж түүх соёлын дурсгалтай ерөнхийлөн танилцсан байна.

2000 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан “Монголын чулуун зэвсгийн үе” төслийн хээрийн шинжилгээний анги Д.Цэвээндорж Б.Гүнчинсүрэн, Я.Цэрэндагва,

А.П.Деревянко, В.Т.Петрин, Д.Олсен нараар удирдуулан явж хайгуулын судалгааны ажил хийн тайланг бичиж нийтлүүлжээ.

2007 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цогтбаатар, Ч.Амартүвшин нар Хүдэр сумын нутаг Төмөртэйн голын савд ажиллан шохой шатааж байсан 5 зуухыг илрүүлэн хэмжилт судалгаа хийн тайланг бичиж боловсруулжээ.

Үүнээс гадна Орхонтуул сумын Өгөөмөр уулын буган хөшөө, Хонгор сумын Буурал уулын монгол булш, Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийдийн гэрэлт хөшөөний бичээс, мөн сумын Амарбаясгалант хийд ззрэг түүх соёлын олон арван дургал эрдэмтэн судлаачдын бүтээлд хэвлэгджээ.

## 2.2. Төв аймагт хийсэн археологийн судалгааны байдал

1912 онд Польш эрдэмтэн В.Л.Котвич Их Хүрээнээс Эрдэнэ зуу орохоор явах замдаа одоогийн Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Баянтөхөм хэмээх газарт буй Их Хөшөөт нэрээр алдаршсан эртний Түрэгийн бичээст хөшөө, олон хүн чулуу, амьтны дүрс бүхий тахилын том онгоныг үзэж судалсан ба 1928 онд түрэг судлаач А.Н.Самойловичийн хамтаар хэвлэн нийтэлжээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт Гуа дов хэмээх туурь хэрлэн голын баруун этгээд Цагаан арал хэмээх газарт, сумын төвөөс зүүн хойш 28 км зайтай оршдог. Гуа дов бол Монголын эртний аман зохиол, түүх судварт Бурхан Халдун уул, Онон, Хэрлэн мөрнүүдтэй эн зэрэгцэн дурдагдаж ирсэн нэн эртний ариун нандин шүтлэгт газар юм.

Гуа довыг 1920-иод оны үед Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга Онходын Жамъян нутгийн ард түмнээс сураглан мэдэж анх олж илрүүлсэн түүхтэй 1924-1925 онуудад урьд тохиолдлоор илэрсэн хүннүгийн язгууртны булшийг Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Хараагийн Ноён уулнаа П.К.Козловын удирдсан Монгол-Түвэдийн шинжилгээний анги малтсанаар манай оронд хүннүгийн оршуулгын дурсгалыг судлах ажил эхэлсэн юм. Ноён уулын булшнаас ховор нандин үнэт олдворууд олдсоны дотор хатгамал ширдэг, торгон эдлэл, хүний нэхмэл дүр хөрөг, хаш чулуун чимэглэл, давтмал алт зэрэг олон зүйлс байсан байна. Бүдүүн цул нарсаар зааж газрын гүнд хийсэн оршуулгын бунхан, ваар сав, амуу будааны зүйл мөн олджээ. Ноён уулын булшуудыг малтсан явдал Монгол орны археологийн судалгаа шинжлэлийн түүхэнд гойд содон хэрэг явдал болж, XX зууны археологийн их нээлтийн нэгд тооцогдох болсон билээ. П.К.Козловын ангийн 1924 оны малтлагын үр дүн ихээхэн анхаарал татаж Ноён уулнаас нээж олсон хүннүгийн язгууртны булш, дурсгалын ач холбогдлыг тодорхойлуулахаар Зөвлөлтийн ШУА-иас мэргэжлийн археологич С.А.Теплоухов, Г.И.Боровка нарыг томилон ирүүлжээ. Тэр шинжилгээний анги нь Туулын (Улаанбаатараас баруун тийш) сав газраар явж 92 булш бүртгэн шинжилж, Ноён ууланд шинжлэх ухааны арга зүйн дагуу 24-р булш буюу үүдэвч, дөрвөлжин далантай нэгэн бунхант булш малтаж, Хүннүгийн үед холбогдохыг тогтоожээ. 1924-1925 онд Ноён ууланд нийт 6 язгууртны бунхан, 4 жижиг булш малтсанаас эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой олон зуун олдвор илэрсэн нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж Монголын археологи, түүний дотор хүннүгийн археологийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн юм.

1926 онд Г.И.Боровка урьд онуудын малтлагаас гарсан олдворуудын заримыг гэрээ ёсоор Судар бичгийн хүрээлэнд шилжүүлэн өгсөн бөгөөд үүнийхээ дараа Ноён ууланд бие даан малтлага хийжээ. Тэрээр Ноён уулын Сүжигтийн аманд нэгэн булш малтсан нь язгууртны бунхан бус банзан австай жижиг булш байжээ. Уг булш хэдийгээр

эрт үед тоногдсон байсан хэдий ч хүннү булшны дотоод зохион байгуулалтын талаар сонирхолтой мэдээлэл өгчээ. Малтлагаар 3 төрлийн шавар сав, ясан аяга, лакан сав, морины дүрстэй хүрэл ялтас, хүрэл хазаар, амгай зэрэг олдвор илэрсэн байна.

1927 онд Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан байсан А.Д.Симуков Ноён уулын Сүжигт, Журамтын аманд язгууртны бунхан тус бүр нэгийг малтсан байна. Тэрээр эсгий ширдэгний тасархай, ургамлын хээтэй давтмал алтны өөдөс, морины алтадмал хавтгай төмөрлөг дүрс, торгоны өөдөс, хятад бичээстэй чий будагтай аяга зэргийн олон тооны сонирхолтой олдвор илрүүлсэн байдаг. Эдгээрийн дотор үүний урьд 6-р булшнаас гарсантай адил хятад бичигтэй лакан аяга байсны хятад бичээсийг тайлан уншихад манай эриний 1-р онд Хятадын Сычуан мужид үйлдсэн болох нь мэдэгдэж Ноён уулын булшны он цагийг нарийвчлан тогтоох боломж олгосон билээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн голын зүүн эрэгт орших эртний дөрвөлжин хэрмийг 1925 онд нэрт хэл шинжээч Б.Я.Владимирцов, буриад эрдэмтэн Бараадын Базар нар анх олж үзэн бага хэмжээгээр малтан судалсан боловч он цагийг тодруулан тогтоож чадаагүй юм. Нутгийн ард түмэн үүнийг “Хасар балгас” хэмээн нэрийддэгийг баримтлан Чингис хааны дүү Хавт Хасарын суусан хот гэж үзсэн байна.

Дэлхийн хоёрдугаар дайны гал ид дүрэлзэж байсан 1942 онд Х. Пэрлээ Төв аймгийн Авдарбаян сумын нутаг Хүйтний голд археологийн судалгаа хийж, эртний булш малтан шинжилсэн байна.

1948-1949 онд ЗХУ-ын ШУА-ийн Түүх-Угсаатны зүйн экспедицийн этнографийн анги Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Наран толгой зэрэг газраас хэд хэдэн буган хөшөө илрүүлснийг К.В.Вяткина хожим нийтэлжээ.

1949 онд ОХУ-ын нэрт археологич С.В.Киселев Тэрэлжийн дөрвөлжин газрын олдворыг Улсын Төв музейд үзээд үүнийг Хүннү улсын үеийн хэрэм гэж он цагийг тогтоосон нь 1952 онд Х.Пэрлээгийн хийсэн малтлага судалгаагаар нотлогджээ. Нийтдээ 235х235 м хэмжээтэй, хэрмийн одоогийн өргөн 10-15 м, өндөр нь 0,5-0,8 м, гүн нь 0,5-0,7 м байжээ. Хэрмийн дотор буй 15х17 м, 20х25 м хэмжээтэй хоёр барилгын орыг малтахад Хүннүгийн үеийн Гуа дов хэмээх барилгын малтлагаас гарсантай тун төстэй дээврийн нөмрөг, тосгуур ваар, хээтэй тоосго зэрэг зүйлс олдсон байна. Энэхүү малтлагын үр дүнд үндэслэж, эрдэмтэн Х.Пэрлээ нь Тэрэлжийн дөрвөлжинг Хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг, Дэнсэлгийн ам гэдэг газарт Х.Пэрлээ 1952 онд түрэгийн үеийн булш малтан шинжилжээ. Хүн чулуутай, балбалтай байсан боловч энэ талаар тодорхой мэдээлэл тайланд байгаагүй ажээ. Нас барсан хүнийг хажуугаар нь хэвтүүлэн оршуулж, төмөр эдлэл хийсэн байв. Хоёр хянгатай төмөр зэв, төмөр гархи, анжисны төмөр хошуу гарсан байна.

1952 онд Х.Пэрлээ Төв аймгийн Мөнгөнморьт сумын Сүүжийн булаг хэмээх газар дөрвөлжин булш малтан шинжилж МЭӨ VII-V зуунд холбогдуулан үзжээ.

1952 онд археологич Х.Пэрлээ Гуа довыг малтан судалж Хүннү гүрний үе буюу МЭӨ II зуун-МЭ I зууны үед хамааруулжээ. Уг дурсгал нь 367 х 360 м хэмжээтэй дөрвөлжин шороон хэрэмтэй бөгөөд дотор талд нь тулгаж барьсан бяцхан барилгын ором, хэрмийн төв хэсэгт 56 м урт, 4 м өргөн, 3 м өндөр шавар барилгын ор байжээ. Х. Пэрлээ энд нийтдээ 12 газар малтаж, дагтаршуулсан шавар шалд суулгасан барилгын баганын суурь чулуу (заримд нь модон баганын хугархай үдсэн байжээ), дээврийн ваарын хагархай, ширмэл ширдэгний хээтэй дөрвөлжин тосгоны хэлтэрхий, олон тооны шатсан тоосго, хятад үсгийн хээтэй төмөр товч, шаазан савны хагархай зэрэг олдворыг олж илрүүлсэн байна. Түүнчлэн хэрмийн зүүн урд өнцгөөс 190 м зайтай нэгэн барилгын үлдцийг малтаж, хөлийг нь атийлган зүүн тийш хандуулж тавиад, дэргэд нь чулуун

зэвсгийн эцсийн үед холбогдмоор сумын ясан зэв дагалдуулсан оршуулга илрүүлжээ. Дээрх бүх олдворт тулгуурлан уг хэрмийг хүннү нарын мандсан үед холбогдох тахилгын дурсгал гэж үзсэн байна.

В.В.Волков 1958, 1964 онд Төв аймгийн нутагт дөрвөлжин булш дөрвийг малтжээ. Тэрээр дөрвөлжин булш, хадны зураг, буган хөшөө, түүвэр олдвор зэргийг нэгтгэн Монголын хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн тухай нэгэн сэдэвт зохиол нийтлүүлсэн юм.

1960 онд А.П.Окладников, Д.Дорж нар Төв аймгийн Тариат сумын Цагаан чулуу, Улаанбаатар хотын дүүрэг Их Тэнгэрийн ам зэрэг газраас хадны зургуудыг илрүүлэн олжээ.

Бороогийн суурин хэмээх Хүннүгийн үед холбогдох туурь нь Төв аймгийн Борнуурын сангийн аж ахуйн нутаг, уг сангийн аж ахуйн төвөөс хойш 30 км зайтай Бороо голын баруун эрэгт буй. Энд Бороогийн алтны уурхайн хуучин төв байх бөгөөд тэнд дэрс, халгай ургасан, барилгын шавар авсан ухмал хонхор, байгалийн хүчин зүйлд идэгдэж нурсан эрэг ганга зэргээс янз бүрийн хээтэй шавар ваар савны хагархай, малын яс ихээр олдож байсныг археологич Ц.Доржсүрэн 1960-аад оны үед үзэж хүннүгийн үед холбогдох суурин газар болохыг анх харьцуулан тогтоожээ.

1961 онд Д. Наваан Гачууртын аманд дөрвөлжин булш нэгийг малтжээ. 1962 онд Монгол-Унгарын хамтарсан экспедици Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт дөрвөлжин булш хэдийг малтсан ажээ

Н.Сэр-Оджав, 1964 онд Төв, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймгийн нутгаас 30 гаруй буган хөшөө олж тодорхойлолт, гар ба гэрэл зургийн хамт нийтэлжээ.

МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги (И.В. Асеев) 1973 онд Төв аймгийн Баян сумын нутаг Хоолтын гол хэмээх газар монголын үед холбогдох булш малтан шинжилж судалгааны ажлын талаар өгүүлэл нийтлэжээ.

1976 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс томилон илгээсэн Хархорум хотыг судлах шинжилгээний анги Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших, XIX зууны үеэс эхлэн олон судлаач үзэж тэмдэглэсэн Өнгөтийн хөшөө хэмээх том дурсгалын малтлага судалгааг эхлүүлж, тахилын тэрхүү онгоны хэмжээ, зохион байгуулалтыг тодруулан, тухайн үеийн барилгын баялаг хэрэглэгдэхүүн, морин цэргийн довтолгооноос хамгаалах “сөргө” хэмээх зэвсэг 100 гаруйг илрүүлэн олсноос гадна шинээр олон тооны хүн чулуудыг нэмж олсон ба энд нийтдээ гуч гаруй хүн чулуу буйг олж тогтоон нийтлүүлж байв.

Төв аймгийн Октябрь сангийн аж ахуйн төвийн ойр Хуц Ухнатай хэмээх газарт чулуугаар хийсэн хүн, амьтны дүрс бүхий нэг дурсгал байдгийг Монгол-Унгарын хамтарсан шинжилгээний анги 1980 онд, МЗТСХЭ-ийн хэсэг 1990 онд тус тус судлан тодорхойлсон байна.

1981 онд А.П.Окладников, “Петроглифы Чулутын-гола” гэдэг номоо нийтэлсэн бөгөөд тус номондоо Төв аймгийн Тариат сумын Байт орчмоос олдсон хадны зургуудыг товч тодорхойлолтын хамт нийтэлжээ.

1980-1982 онуудад МЗТСХЭ-ийн хүрэл, төмөр зэвсгийн дурсгал судлах анги Архангай, Булган, Сэлэнгэ, Төв аймгийн нутагт 40 орчим хүннү булш малтан судалжээ.

1983 онд МЗТСХЭ (Д.Наваан, Т.Санжмятав, Х.Лхагвасүрэн нар) Төв аймгийн Алтанбулаг сумын Тариат багийн нутаг Алтанцэцэгийн адаг, Морин толгойд тус бүр хоёр, монгол булш малтан судалсан байна. Булшны үнэмлэхүй он цагийг тодорхойлсон нийтлэл байхгүй.

Судлаач Г.Мэнэс МЗТСХЭ-ийн бүрэлдэхүүнд ажиллахдаа Налайхын Тоньюкукын цогцолбор, түүний ойр орчимд буй дурсгалууд, Төв аймгийн Дэлгэрхаан сумын Их хөшөөт, Туулын Улхын булан, Өвөрхангайн Бүрд сумын нутаг дахь хүн чулуу зэрэг нэлээд тооны дурсгалыг шинжилж нарийн тодорхой зураг үйлдэн эрдэм

шинжилгээний үүднээс тодорхойлж, түрэгийн тахилын онгон малтан судлах ажлыг гүйцэтгэж ирэв.

1984 онд МЗТСХЭ болон “Сэлэнгэ, Булган, Хөвсгөлийн экспедици” (Д.Наваан, Т.Санжмятав, Х.Лхагвасүрэн нар) Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Сөгнөгөрийн голын сав Цагаан нуга хэмээх газар гурван монгол булш малтжээ .

1984 онд Х.Лхагвасүрэн Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгойд дөрвөн булш малтан шинжилжээ. Булшны материал нийтлэгдээгүй.

1984 онд Д.Наваан Төв аймгийн Өндөрширээт сумын Майхан уул хэмээхгазар нэг монгол булш малтан судалжээ. Тус булшны материал нийтлэгдээгүй.

1987 онд археологич Г.Мэнэс Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Чимэгт овоо гэдэг газар нэг булш малтан шинжилжээ. Дээрхи “Палеоэтнографийн анги” язгуурын монголчуудын голомт нутаг Гурван голын савд монгол булшны талаар нилээд ултай судалгаа хийж эхэлсэн боловч дөрөв таван жилийн дараа хаагдснаас гадна судалгааны эх хэрэглэгдэхүүн нь одоо болтол хэвлэн нийтлэгдээгүй байна.

1988 МЗТСХЭ-ийн В.Е.Войтов, Д.Баяр нарын бүрэлдэхүүнтэй “Хангайн анги” онд Төв аймгийн Баян сумын Хангайн булагт 2 хүн чулууг нягтлан судалж зураг, тодорхойлолт үйлдсэн юм.

Монгол-Унгарын хамтарсан археологийн шинжилгээний анги 1988 онд Төв аймгийн Баян сумын Зараа толгойд 17 хүннүгийн үед холбогдох булш илрүүлж 5-ыг малтан судалжээ.

МЗТСХЭ-ийн судалгааны ангиуд Монголын төв нутгаар урьд өмнөх судлаачдын зам гудас үзэж тэмдэглэсэн зарим дурсгалыг давтан судалж тодруулахын хамт шинээр мөн багагүй тооны дурсгалыг судлан үзэж тодорхойлж байлаа. Тус анги нь 1988 онд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Төв, Ховд аймгуудын нутгаар 4600 км гаруй урт зам туулан хайгуул судалгааны ажил гүйцэтгэсэн бөгөөд энэ ажлын явцад Их Монгол улсын үед холбогдох зарим хүн чулууны дурсгалыг нягтлан үзэхийн зэрэгцээ шинээр ч зарим дурсгалыг илрүүлж олсон юм. Төв аймгийн Баянцагаан сумын нутаг Хүүхэн хонгор хэмээх уулын өвөрт, түшлэгтэй сандалд суусан эр, эм хүний дүрстэй 2 хөшөө, Баян сумын нутаг Бага хангай уулын өвөр Хангайн булаг хэмээх газарт болхидуухан хийцтэй боловч хийц дүрслэлийн хувьд Дорнод Монголын хүн чулууны бүлэгт багтах 2 хүн чулуу зэргийг шинээр илрүүлж олсон билээ.

Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан Хүннүгийн дурсгал судлах анги 1989 онд Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойд 2 хүннү булш малтаж нилээд тооны эд өлгийн зүйлс олжээ.

1990 онд Д.Цэвээндорж, И.Эрдели нарын удирдсан Монгол-Унгарын хамтарсан шинжилгээний анги Төв аймгийн Борнуур сумын нутагт орших Бороогийн сууринд малтлага судалгааны ажил эхлүүлжээ. Энэ суурингаас олдсон том, жижиг ваар савны зүйлс нь хэмжээ, хэлбэр, хийц, хээ угалзны шинж төрх зэргийн хувьд Хараагийн Ноён уулын булшнаас гарсан зүйлстэй ижил бөгөөд уг суурин, энэхүү булшны газар хоёр ойр зэргэлдээ оршиж байгаагаас үзэхэд Ноён уулын булшинд тавьсан ваар савыг Бороогийн сууринд үйлдвэрлэж байсан бололтой хэмээх урьдчилсан саналыг судлаачид дэвшүүлжээ.

1990-1993 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцсон археологичид 1990 онд Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Номгон уулын энгэрээс баргил залтас, хянгар маягийн зэвсэг, Хэрлэн голын баруун эрэг, Зүүн Байдлагийн гол, Тогос уул, Сангайн ам, Сүүжийн дэнж, Номгон толгой, Зорголын шар хад, Хустын булаг зэрэг газраас палеолитын үед холбогдох баргил залтас, дугуй үлдэц, хусуур, үзүүр мэс, гилбэр маягийн эдлэл нэлээд хэмжээгээр олджээ.

Туркийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (TICA) санхүүжилтээр хэрэгжиж буй Монгол-Туркийн эрдэмтдийн хамтарсан "Монгол дахь Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, судлах, сэргээн засварлах" төсөл нь түрэгийн үеийн тахилын онгон, хүн чулууны судлалд үлэмж ач холбогдолтой ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү төслийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь Архангайн Хөшөө Цайдамд буй Билгэ хаан, Күль-Тегиний онгон, Налайхад буй мэргэн сайд Тоньюкукын тахилын онгон зэрэг томхон дурсгалуудыг малтан судалж орчин үеийн дэвшилтэт арга зүй хэрэглэн сэргээн засварлаж олон нийтийн үзэх үзмэр болгох; чиглэж байгаа билээ.

Тус төслийн үйл ажиллагаа 1997 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд эхний жилд Төв аймгийн Баянцогт сумын нутаг Налайхын орчимд байх Дорнод Түрэг улсын төрийн зөвлөх сайд Тоньюкукын болон Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдамын дурсгалуудыг тандан судалж, цаашдын нарийвчилсан судалгаа, сэргээн засварлалтын ажлын бэлтгэлийг хангасан болно. Мөн эдгээр газарт топографийн хэмжилт хийж нарийвчилсан зураг үйлдэхэд бэлэн болгох ажлыг гүйцэтгэсэн юм.

1999 онд Монгол-Солонгосын хамтарсан "Монсол" төслийн хээрийн шинжилгээний анги Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Их Хөтөл хэмээх газар монголын үеийн булш нэгийг малтаж хээрийн шинжилгээний тайланг солонгос, монгол хэлээр хэвлэжээ.

2000 онд Монгол-Солонгосын хамтарсан "Мон-Сол" төслийн судлаачид Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойн хүннүгийн оршуулгын газарт нэгэн хүннү булш малтаж тайланг хэвлүүлсэн байна.

2002 оноос Монгол-Швейцарийн археологчид хамтран Төв аймгийн нутагт орших Бороогийн сууринд малтлага судалааны ажил хийж гүйцэтгэсэн юм. Судалгааны байдлаас үзэхэд энэ суурин газарт гар үйлдвэрлэл ихэд хөгжсөн бөгөөд энд хүмүүс олноор суурьшин амьдарч, вааран савны үйлдвэрийг дагнан эрхлэхийн сацуу газар тариалан болон бусад төрлийн үйлдвэрлэлийг эрхэлж байсан нь тодорхой болжээ. Энэхүү сууринд малтан шинжилсэн орон сууцны хийц, зохион байгуулалт нь ОХУ-ын Буриадын нутагт, Сэлэнгэ мөрний хөвөөнд байдаг Иволгын сууринтийнхтай адил байгаа, мөн эндхийн болон Ноён уулын вааран савны найрлага нь спектр задлан шинжилгээний дүнд яг ижил байсан зэрэг ихээхэн сонирхолтой үр дүнд хүрсэн нь уг суурин газрын судалгааг цаашид үргэлжүүлж бүх талбайгаар нь малтан судлах шаардлагатайг харуулж байна.

Монголын Үндэсний Түүхийн Музейн археологийн экспедици 2002 онд Морин толгойд 2 хүннү булш малтан судалсан байна.

2003 онд судлаач Ц.Төрбат Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Эрдэнэхайрхан уул орчимд 10 орчим дөрвөлжин булш малтан шинжилсэн бөгөөд энэ талаар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтэлжээ. Тэрээр энэхүү өгүүлэлдээ, нийт дөрвөлжин булшны он цаг, дотоод ангилалын талаар өөрийн саналыг дэвшүүлэн тавьсан бөгөөд дээрх судалгаанд хамрагдсан дөрвөлжин булшнуудыг МЭӨ VIII-IV зуунд хамрагдах "Туулын хэлбэрийн булш" хэмээн ангилах санал дэвшүүлсэн байна.

2006 оноос Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи-Угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Ноён ууланд хүннүгийн язгууртны булшны судалгааны ажлыг үргэлжлүүлэх болов. Энэхүү шинжилгээний ангийн судлаачид 2006 оны 5-10 сар хүртлэх хугацаанд Сужигтийн аманд хүннүгийн язгууртны 1 булшийг бүрэн хэмжээгээр малтан судалсан байна. Булшны оршуулгын бунхан нь 18 метрийн гүнээс илэрчээ. Малтлагаас дээрээ шүхэртэй морин тэрэгний эд ангиуд, түүний хүрэл, мөнгөн тоноглол, нэхмэл ширдэг, чий будагтай хятад бичээст аяга, хүрэл сав суулга зэрэг олон тооны сонирхолтой эд өлгийн зүйлс гарсан нь 1920-иод оны Ноён уулын малтлагаас олдсон

зүйлстэй үндсэндээ ижилсэж байна. Эдгээрийн дотор европ хүмүүсийн дүрс бүхий хөөмөл мөнгөн чимэглэл буй нь ихээхэн сонирхолтой бөгөөд энэ нь хүнүчүүдийн худалдаа, соёлын харилцааны түүхэнд холбогдох онцгой чухал олдворт тооцогдоно.

## 3. АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

### 2.1. Археологийн дурсгалуудын тодорхойлолт

| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |
|---|---|---|---|---|---|

| Дурсгалын дугаар | *01* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
|---|---|---|---|
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Буган хөшөө | |
|---|---|---|---|---|---|
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 11.0<br>E105 24 29.0 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 775 | | | Сайн | √ |
| Хэмжээ | Өндөр | 120 см | | Дунд | |
| | Өргөн | 90 см | | Муу | |
| | Зузаан | 25 см | | | |
| Дагуул байгууламж | Тоо | 2 | Гэрэл зургийн дугаар | | |

| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
|---|---|---|---|---|---|
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | √ | | Дунд | |
| | Уулын бэлд | | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | √ |
| | Бусад | | | Элс | |

| Түүвэр олдвор | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . . | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| Буган чулуу нь баруун болон баруун урд талдаа 1 м голч бүхий дагуул байгууламжтай бөгөөд тэдгээр нь дүгрэг хэлбэртэй ажээ. |

Гэрэл зураг









## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *02* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Хиргисүүр | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 20.2<br>E105 24 42.6 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 789 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 10 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 10 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 10 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | √ | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | √ | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Түүвэр олдвор | | | | | |
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| |
|---|
| Бусад тэмдэглэл |
| |

Гэрэл зураг





## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *03* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Хиргисүүр | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 33.1<br>E105 24 46.1 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 798 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 20 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 20 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 20 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | 9 | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | √ | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| Түүвэр олдвор | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | ............ | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | ............ | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | ............ | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | ............ | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| Энэ нь дөрвөлжин хүрээтэй голдоо 6 м овгор дараастай бөгөөд эргэн тойронд нь 9 дагуул мэдэгдэж байна. |

Гэрэл зураг





## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *04-08* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Булш | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүннү | |
| Солбицол | N49 03 35.8<br>E105 24 47.1 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 799 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 3-6 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 3-6 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 3-6 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | √ | | Дунд | |
| | Уулын бэлд | | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Түүвэр олдвор | | | | | |
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| |
|---|
| Бусад тэмдэглэл |
| 5х10 м талбайд 5 булш бүхий хүннүгийн оршуулгын газар байна. |

| Гэрэл зураг |
| --- |









## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *09-17* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Булш | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүннү | |
| Солбицол | N49 03 40.7<br>E105 24 46.8 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 799 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 3-5 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 3-5 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 3-5 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | √ | | Дунд | |
| | Уулын бэлд | | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Түүвэр олдвор | | | | | |
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| 20x20 м талбайд 12 булш бүхий хүннүгийн оршуулгын газар байна.<br>Энэ дурсгалаас баруун хойш болон зүүн хойш 150 м орчим талбайд мөн 10 орчим булш бий. |

Гэрэл зураг









## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |
|---|---|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *18* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Хиргисүүр | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 44.2<br>E105 24 06.2 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 768 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 18 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 18 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 18 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | 3 | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | √ | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| Түүвэр олдвор | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | ............ | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | ............ | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | ............ | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | ............ | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| Энэ нь дөрвөлжин хүрээтэй голдоо 8 м овгор дараастай бөгөөд эргэн тойронд нь 3 дагуул мэдэгдэж байна. |

Гэрэл зураг





## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *19* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Хиргисүүр | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 47.1<br>E105 24 09.7 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 778 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 10 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 10 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 10 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | √ | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Түүвэр олдвор | | | | | |
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| |
|---|
| Бусад тэмдэглэл |
| Энэ нь дөрвөлжин хүрээтэй голдоо 6 м овгор дараастай бөгөөд эргэн тойронд нь дагуул мэдэгдэхгүй байна. |

Гэрэл зураг



## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *20* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Хиргисүүр | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 45.4<br>E105 23 56.2 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 768 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 15 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 15 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 15 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | √ | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| Түүвэр олдвор | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| Энэ нь дөрвөлжин хүрээтэй голдоо 6 м овгор дараастай бөгөөд эргэн тойронд нь дагуул мэдэгдэхгүй байна. |

Гэрэл зураг





## ДУРСГАЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

| Огноо | | Цаг | | Бүртгэгч | А.Энхтөр, Т.Батбаяр, Э.Амарболд |
|---|---|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| Дурсгалын дугаар | *21* | Хайгуулын талбайн нэр | Улаанбаатар, Дархан-Орхон |
| Хайгуулын талбайн хэмжээ | 92,277 км | Лиценз / тусгай зөвшөөрлийн дугаар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Аймаг | Сэлэнгэ | | Дурсгалын төрөл | Булш | |
| Сум | Орхон | | Он цаг | Хүрэл зэвсгийн үе | |
| Солбицол | N49 03 42.0<br>E105 23 49.9 | | Хадгалалт | Маш сайн | |
| ДТД өндөр | 755 | | | Сайн | |
| Хэмжээ | Голч | 2,5 м | | Дунд | √ |
| | Уртрагийн дагуу | 2,5 м | | Муу | |
| | Өргөргийн дагуу | 2,5 м | | | |
| Дагуул байгууламж | Тоо | | Гэрэл зургийн дугаар | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрчлөлт | Малтсан | | Гол, горхи, сайр хүртлэх зай | Чиглэл | |
| | Тоносон | | | Зай | |
| Газрын тогтоц | Уулын оройд | | Ургамал | Өндөр | |
| | Уулын налуу энгэрт | | | Дунд | |
| | Уулын бэлд | √ | | Тачир | √ |
| | Голын (жалганы) дэнж (эрэг) дээр | | Хөрс | Хар | |
| | Тэгш талд | | | Бор | |
| | Бусад | | | Элс | √ |

| Түүвэр олдвор | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Чулуун зэвсэг | | Чулуужсан яс | | . . . . . . . . . . . . | |
| Ваарны хагархай | | Төмрийн баас | | . . . . . . . . . . . . | |
| Хүрэл эдлэл | | Чулуун эдлэл | | . . . . . . . . . . . . | |
| Төмөр эдлэл | | Бутлуур чулуу | | . . . . . . . . . . . . | |

| Бусад тэмдэглэл |
|---|
| |

Гэрэл зураг



### 2.2. Замын трассын ойр орчмоос илэрсэн дурсгалуудын байршил

| Д/д | Солбилцол | Замын цэг | Замын тэнхлэгээс дурсгал хүртэлх зай | Нэмэлт мэдээлэл- Замын трасст |
|---|---|---|---|---|
| 1 | N49 03 11.0 E105 24 29.0 | 45 | 10 м | Өртсөн |
| 2 | N49 03 20.2 E105 24 42.6 | 45 | 400 м | Анхаарах |
| 3 | N49 03 33.1 E105 24 46.1 | 45 | 780 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 4-8 | N49 03 35.8 E105 24 47.1 | 45 | 800 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 9-17 | N49 03 40.7 E105 24 46.8 | 45 | 900 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 18 | N49 03 44.2 E105 24 06.2 | 46 | 380 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 19 | N49 03 47.1 E105 24 09.7 | 46 | 490 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 20 | N49 03 45.4 E105 23 56.2 | 46 | 230 м | Тэмдэг, тэмдэглэгээ |
| 21 | N49 03 42.0 E105 23 49.9 | 46 | 40 м | Өртсөн |

Хавсралт №1. **ЗАМЫН ТРАССЫН ДАГУУД БУЙ ДУРСГАЛУУДЫН ТАРХЦЫГ ХАРУУЛСАН ЗУРАГ**



Хавсралт №2. **ЗАМЫН ТРАССТ ӨРТӨЖ УСТАЖ БОЛЗОШГҮЙ ДУРСГАЛУУДЫН БА АВРАН ХАМГААЛАХ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, МАЛТАН СУДЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

| Д/д | Солбилцол | Замын цэг | Замын тэнхлэгээс дурсгал хүртэлх зай | Авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх зардал (Мянган,төг) |
|---|---|---|---|---|
| 1 | N49 03 11.0 E105 24 29.0 | 45 | 10 м | 4500,000 |
| 21 | N49 03 42.0 E105 23 49.9 | 46 | 40 м | 4500,000 |
| | Нийт 2 дурсгалыг малтан судалж нүүлгэн шилжүүлэх зардал | | | 9,000,000 |
| | | | | Есөн сая төгрөг |

Жич : Энэ зардалд татвар хураамж бүгд багтсан болно.

## 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Дархан-Эрдэнэтийн чиглэлийн улсын чанартай А1001 авто замын Орхон сумын уулзвартай холбох 92,277 км замын гол шугамын дагуу хайгуул судалгааны ажлыг 2021 оны 10 дугаар сарын 22-ноос 25-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрхлэгч, доктор (Ph.D), А.Энхтөр, доктор (Ph.D) Т.Батбаяр, Э.Амарболд нар ажиллав.

Хайгуул судалгааг гүйцэтгэхдээ археологийн шугаман хайгуулын арга, агаарын зургийн хайгуулын аргыг тус тус ашиглав.

Хайгуул судалгааны үед нийт 21 археологийн дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Эдгээрээс 2 дурсгал замын бүтээн байгуулалтын явцад шууд өртөж устах аюултай байгаа бол бусад нь нөлөөллийн бүсэд оршиж байна. Үүнд:

1. Дурсгал № 1 нь замын трасст шууд өртөж устахаар байна. Уг дурсгалыг хуулийн дагуу авран хамгаалах малтлага судалгаа хийж чөлөөлөх эс бөгөөс замын трассыг өөрчлөх шаардлагатай.
2. Дурсгал № 21 хэмээн бүртгэн баримтжуулсан дурсгалыг туслах зам тавих, хүнд техникийн хөдөлгөөн зэргээс хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай байна.
3. Мөн үлдсэн № 2, 3, 4-8, 9-17, 18, 19, 20 дугаартай дурсгалуудыг замын зураг төсөл, ажлын зураг зэрэгт тусган тэмдэглэх, анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ босгох шаардлагатай.

Замын трассыг өөрчилсөн тохиолдолд, дээрх 2 дурсгалын аль нэг нь ямар ч тохиолдолд шинээр баригдах зам, барилгын бүтээн байгуулалтын ажилд өртөн устах аюултай байгаа тул хуулийн дагуу археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийж замын трассыг чөлөөлөх шаардлагатай байна.

Мөн түүнчлэн зам барилгад хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болох чулуун болон шорооны карьер байгуулах тохиолдолд тухайн цэгүүдэд дахин археологийн хайгуул, тандалт судалгааг Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу хийлгэх шаардлагатай юм.

## Ажилласан газрын тэмдэглэл

| № | Очсон газрын нэр | Очсон сар, өдөр (тамга) | Буцсан сар, өдөр (тамга) | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| | Орхон сум [illegible] | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

**МОНГОЛ УЛС**
**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

Эрдэм шинжилгээний
# АЛБАН ТОМИЛОЛТ

**Улаанбаатар хот**

**№ 55**

**Олгосон 2021 оны 10-р сарын 22 өдөр**
**Замд гарсан 2021 оны 10-р сарын 25 өдөр**

**Албан тушаал** Салбарын эрхлэгч, доктор (Ph.D)
**Овог** Алтангэрэл
**Нэр** Энхтөр
**Томилолтод хамрагдах хүмүүс:**
Ж. Батбаяр, Э. Амарболд, жолооч-1

**Ажиллах газрын нэр:** Дархан уул, Орхон, Булган аймгийн нутгаар археологийн хайгуул судалгааны (Сэлэнгэ аймаг)

**ажлаар томилсон тул энэ үнэмлэхийг** 4 **хоногийн хугацаагаар олгов.**

***Захирал:*** /Г. Эрэгзэн/

9019090235 6471072

**Ажлыг хэрхэн гүйцэтгэсэн тухай тодорхойлолт**

**201. . оны . . . -р сарын . . . -д буцаж ирлээ.**

(Захирлын гарын үсэг)